



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

**Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд төрийн өмчийг төлөөлөн оролцох төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Ц.Шинэхүүг томилсугай.

2. “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Ц.Шинэхүүд даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000025

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



**“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД ТӨРИЙН
ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт, санал өгч оролцох;

2. Компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг хэлэлцэн батлах;

3. Компанийг нээлттэй хувьцаат компани болгох талаар авах арга хэмжээний тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг хэлэлцэн батлах;

4. “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахад санал өгч оролцох.

-----oOo-----

0000250